



МОНГОЛ УЛСЫН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН  
ТУШААЛ

2021 оны 04 сарын 01 өдөр

Дугаар №039

Улаанбаатар хот

Түр журам, үнэлгээний хуудас  
батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1, 36 дугаар зүйлийн 36.1, Коронавируст халдварт (КОВИД-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

- “Коронавируст халдварт (КОВИД-19)-ын батлагдсан тохиолдлын гэрийн тусгаарлалтад эмчлэгдэх өвчтөнд эмнэлгийн тусlamж, үйлчилгээ үзүүлэх түр журам”-ыг нэгдүгээр, “Коронавируст халдварт (КОВИД-19)-ын батлагдсан тохиолдлын гэрийн тусгаарлалтад эмчлэгдэх өвчтөн /үйлчлүүлэгч/-д хийх үнэлгээний хуудас”, “Коронавируст халдварт (КОВИД-19)-ын батлагдсан тохиолдлын гэрийн тусгаарлалтад эмчлэгдэж байгаа өвчтөн /үйлчлүүлэгч/-ий өөрийгөө хянах хуудас”-ыг хоёрдугаар, “Коронавируст халдварт (КОВИД-19)-ын батлагдсан тохиолдлын гэрийн тусгаарлалтад эмчлэгдэх өвчтөн /үйлчлүүлэгч/-ий зөвшөөрлийн хуудас”-ыг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.
- Энэхүү тушаалыг хэрэгжүүлж ажиллахыг Аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар, эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал наарт тус тус үүрэг болгосугай.
- Тушаалыг хэрэгжүүлэхэд мэргэжил арга зүйгээр хангаж ажиллахыг Эмнэлгийн тусlamжийн бодлого, хэрэгжилтийг зохицуулах газар (Б.Буянтогтох), Халдварт өвчин судлалын үндэсний төв (Л.Баттөр) -д тус тус даалгасугай.
- Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээний газар (Д.Ганцэцэг)-т даалгасугай.

САЙД



С. Энхболд /

С.ЭНХБОЛД

141211166

“Коронавируст халдварт (КОВИД-19)-ын батлагдсан тохиолдлын  
гэрийн тусгаарлалтад эмчлэгдэх өвчтөнд эмнэлгийн  
тусlamж, үйлчилгээ үзүүлэх түр журам

**Нэг. Нийтлэг үндэслэл**

1.1. Энэхүү журмаар коронавируст халдварт (КОВИД-19)-ын батлагдсан тохиолдлын эмнэлзүйн шинж тэмдэггүй болон хөнгөн хэлбэрийн шинж тэмдэг илэрсэн тохиолдлыг гэрийн тусгаарлалтад эмчлэх, хянах, эмнэлгийн тусlamж, үйлчилгээ үзүүлэх, хариу арга хэмжээ авахад оролцогч талуудын үүрэг, хариуцлагатай холбогдон үүсэх харилцааг зохицуулна.

1.2. Коронавируст халдварт (КОВИД-19)-ын батлагдсан тохиолдлын эмнэлзүйн шинж тэмдэггүй болон хөнгөн хэлбэрийн шинж тэмдэгтэй өвчтөн /үйлчлүүлэгч/-г гэрийн тусгаарлалтад эмчлэх, хянах, эмнэлгийн тусlamж, үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааг улсын хэмжээнд Халдварт өвчин судлалын үндэсний төв, аймаг, нийслэлийн хэмжээнд Эрүүл мэндийн газар мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж ажиллана.

1.3. Коронавируст халдварт (КОВИД-19)-ын батлагдсан тохиолдолд тандалтын эсхүл эмнэлзүйн баг удирдамж, зааврын дагуу үзлэг, оношилгоо, үнэлгээ хийж, өвчтөн /үйлчлүүлэгч/-г гэрийн тусгаарлалтад эмчлэх, хянах эсэх тухай шийдвэр гаргаж, харьяа өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвд мэдээлнэ.

1.4. Коронавируст халдварт (КОВИД-19)-ын батлагдсан тохиолдлын гэрийн тусгаарлалтад эмчлэгдэх өвчтөн /үйлчлүүлэгч/-д үзүүлэх эрүүл мэндийн тусlamж, үйлчилгээг харьяа өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төв хариуцаж, Аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар /нийслэлд дүүрэг/-аас томилогдсон мэргэжлийн багуудтай хамтран ажиллана.

1.5. Өвчтөн /үйлчлүүлэгч/-д үзүүлэх эрүүл мэндийн тусlamж, үйлчилгээнд эмчийн үзлэг, эмчилгээ, хяналт, тандалт, сэтгэл зүйн зөвлөгөө, түргэн тусlamжийн үйлчилгээ, хэвтүүлэн эмчлэх тусlamж, үйлчилгээ хамаарна.

1.6. Гэрийн тусгаарлалтад эмчлэгдэх өвчтөн /үйлчлүүлэгч/-ий хяналт, тусlamж, үйлчилгээтэй холбоотой мэдээ, мэдээллийг цуглуулах, дамжуулах, тайлагнах үйл ажиллагаанд тандалтын онлайн систем /цаашид тандалтын систем гэх/-ийг ашиглана.

1.7. Тандалтын системийн тохиргоог аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газрын болон эрүүл мэндийн байгууллагын мэдээллийн технологийн мэргэжилтэн, инженер хариуцах ба удирдлагын шийдвэрийг үндэслэж эмч, ажилтнуудад ашиглах эрх олгоно.

1.8. Тандалтын системийг ашиглаж байгаа эмч, ажилтнууд нь цахим мэдээллийн нууцлал, аюулгүй байдлыг хангах үүрэг хүлээнэ.

## **Хоёр. Гэрийн тусгаарлалтад эмчилж, хянах шалгуур**

2.1. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын батлагдсан тохиолдолд дараах шалгуурыг харгалзан өвчтөн /үйлчлүүлэгч/-г гэрийн тусгаарлалтад эмчлэх, хянах эсэх тухай шийдвэр гаргана:

2.1.1. Өвчтөн /үйлчлүүлэгч/ коронавируст халдвар (КОВИД-19)ын эмнэлзүйн шинж тэмдэггүй болон хөнгөн хэлбэрээр өвчилсөн гэж оношлогдсон, архаг өвчин эмгэггүй,

2.1.2. Ам бүл цөөн, гэр бүлийн гишүүдийн дотор эрсдэлт бүлгийн хүн байхгүй,

2.1.3. Өвчтөн /үйлчлүүлэгч/ өөрөө болон гэр бүлийн бүх гишүүн гэрт нь тусгаарлан эмчлэхийг зөвшөөрсөн, асран халамжлах хүнтэй байх,

2.1.4. Гэр ахуйн орчин нь эрүүл ахуйн шаардлага хангасан, өвчтөн /үйлчлүүлэгч/-г тусад нь нэг өрөөнд тусгаарлах, халдвараас сэргийлэх дэглэм мөрдөх боломжтой,

2.1.5. Өвчтөн /үйлчлүүлэгч/ өөрөө болон асран халамжлагч нь биеийн байдлыг хянаж, эмнэлгийн мэргэжилтэнд тогтмол мэдээлэл өгөх чадвартай,

2.1.6. Мэдээлэл солилцох гар утас болон интернэт сүлжээнд холбогдсон,

2.1.7. Хоол хүнс, ариун цэврийн хэрэгсэл болон ахуйн хэрэглээний цэвэрлэгээ, халдваргүйтгэлийн материал худалдан авч хэрэглэх санхүүгийн боломжтой.

2.2. 2.1-д заасан шалгуурыг хангасан тохиолдолд өвчтөн, асран халамжлагч, гэр бүлийн гишүүдээс батлагдсан зөвшөөрлийн хуудсаар зөвшөөрлийг бичгээр авч баталгаажуулах ба тандалтын системд мэдээллийг оруулна.

## **Гурав. Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвийн эрх, үүрэг**

3.1. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын батлагдсан тохиолдлын эмнэлзүйн шинж тэмдэггүй болон хөнгөн хэлбэрийн шинж тэмдэгтэй гэрийн тусгаарлалтад байгаа өвчтөн /үйлчлүүлэгч/-ий эмчилгээ, хяналтыг өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвийн эмч болон бусад эмнэлгийн мэргэжилтнүүд хийнэ.

3.2. Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвийн дарга нь тандалтын болон эмнэлзүйн багийн үнэлгээгээр гэрийн тусгаарлалтад эмчилж, хянах шийдвэр гарсан тохиолдлын мэдээллийг авч, өвчтөн /үйлчлүүлэгч/ болон гэр бүлийн гишүүдийн бүртгэлийг тандалтын системийн бүртгэлтэй тулгаж, хянах ба тухайн өвчтөнг эмчилж, хянах эмч, сувилагчийг томилж, холбогдох утасны дугаарыг тэмдэглүүлнэ.

3.3. Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвийн эмч нь өвчтөн /үйлчлүүлэгч/-д утсаар болон цахимаар асуумж авч, өвчтөн /үйлчлүүлэгч/-ий биеийн байдлыг үнэлэн эрүүл мэндийн болон халдвараас сэргийлэх зөвлөгөө өгч, цаашдын эмчилгээ, хяналтыг төлөвлөнө.

3.4. Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвийн эмч нь өвчтөн /үйлчлүүлэгч/-тэй өдөрт 2 удаа утсаар холбогдож, тандалтын системийн “Эрүүл мэндийн хяналт” хэсэгт байршуулсан өөрийгөө үнэлэх хуудсаар өвчтөн /үйлчлүүлэгч/-ий өгсөн мэдээлэл болон бусад байгууллагын бүртгэл, мэдээлэлтэй танилцаж цахимаар хянана. Өөрийгөө үнэлэх хуудсаар мэдээлэл өгөөгүй өвчтөн /үйлчлүүлэгч/-тэй утсаар холбогдон биеийн байдалд үнэлгээ өгч, тандалтын системд мэдээллийг оруулна.

3.5. Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвийн эмч нь шаардлагатай тохиолдолд өвчтөн /үйлчлүүлэгч/-г гэрээр өдрийн эмчилгээнд хамруулна.

3.6. Гэрийн тусгаарлалтад эмчлэгдэж байгаа өвчтөн /үйлчлүүлэгч/-д эмчилгээ, хяналтын явцад халдвараас сэргийлэх дэглэм, батлагдсан үнэлгээний хуудсын дагуу өөрөө өөрийгөө хянах хуудас” (маягт 2)-ыг хэрхэн бөглөх талаар зааварчилгаа өгч, хяналт тавина.

3.7. Эмнэлгийн тусlamж, үйлчилгээнд нэн шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгсэл, хамгаалах хувцас хэрэгслийн нөөцийн жагсаалтыг гаргаж, хангана.

3.8. Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвийн эмч нь гэрийн тусгаарлалтад эмчлэгдэж байгаа өвчтөн /үйлчлүүлэгч/-г эдгэртэл биеийн байдал, илэрч буй эмнэлзүйн шинж тэмдгийг хянаж, эрүүл мэндийн зөвлөгөө мэдээлэл болон сэтгэл зүйн зөвлөгөө өгч, шаардлагатай тохиолдолд лавлагаа шатлалын эмч нараас зөвлөгөө авч тусlamж, үйлчилгээ үзүүлнэ.

3.9. Өвчтөн /үйлчлүүлэгч/-д коронавируст халдвар (КОВИД-19)-ын эмнэлзүйн шинж тэмдэг нэмж илэрсэн, зөвлөгөө авах шаардлага гарсан тохиолдолд нийслэлд харьяа дүүргийн эмнэлгийн тусlamжийн багт, аймагт Эрүүл мэндийн газрын эмнэлзүйн болон шуурхай ажиллагааны багт утсаар яаралтай мэдэгдэж, тусlamж, үйлчилгээ үзүүлнэ.

3.10. Нийслэлд дүүргийн эмнэлгийн тусlamжийн баг нь шаардлагатай тохиолдолд гэрт нь очиж үзлэг, оношилгоо хийж, эмнэлэгт хэвтүүлэн эмчлэх тусlamж, үйлчилгээг зохицуулна. Аймаг, орон нутагт энэхүү журмын 5.7-д заасан дагуу тусlamж, үйлчилгээ үзүүлнэ.

3.11. Өвчтөн /үйлчлүүлэгч/-ий хамт амьдарч байгаа гэр бүлийн гишүүдэд коронавируст халдвартын эмнэлзүйн шинж тэмдэг илэрсэн тохиолдолд полимеразын гинжин урвал /бх-ПГУ/-ын шинжилгээ хүлээхгүйгээр эрэмбэлэн ангилж, тусгаарлан тусlamж, үйлчилгээ үзүүлэх ба нийслэлд харьяа дүүргийн тандалтын болон эмнэлгийн тусlamжийн багт, аймагт Эрүүл мэндийн газрын тандалтын багт яаралтай мэдэгдэнэ.

3.12. Гэрийн тусгаарлалтад байгаа өвчтөний эмчилгээ, хяналт, тусlamж, үйлчилгээ, эмнэлэгт хэвтүүлсэн, өөр аймаг, дүүрэг, байгууллагад шилжүүлсэн, эмчийн хяналтаас гаргасан тухай мэдээ, мэдээллийг тандалтын системд тухай бүр үнэн зөв хөтөлнө.

3.13. Гэрийн тусгаарлалтад эмчлэх, хянах үйл ажиллагаанд саад учруулж байгаа иргэдийг холбогдох байгууллагад мэдээлнэ.

3.14. Өвчтөн /үйлчлүүлэгч/-д дараах дэмжих үйлчилгээ шаардлагатай тохиолдолд харьяа орон нутгийн онцгой комисстoy хамтран ажиллана:

- 3.14.1. Иргэдийн хүсэлтээр хоол хүнс, ахуйн хэрэглээний бараа хүргэж өгөх,
- 3.14.2. Хог хаягдлыг цуглуулах, халдвартгүйтгэл хийх,
- 3.14.3. Хөл хорионд хяналт тавих,
- 3.14.4. Бусад нийгмийн хамгааллын үйлчилгээ.

## **Дөрөв. Өвчтөн /үйлчлүүлэгч/-ийн эрх, үүрэг**

4.1. Коронавируст халдвар (КОВИД-19)-тай нь батлагдсан өвчтөн /үйлчлүүлэгч/ нь эмчийн зааврын дагуу тандалтын системийн цахим асуумж (маягт 2)-ийг бөглөж, эрүүл мэндийн байгууллагад биеийн байдлын талаар үнэн, зөв мэдээлэл өгнө.

4.2. Өвчтөн /үйлчлүүлэгч/ нь батлагдсан зөвшөөрлийн хуудас (маягт 3)- аар гэртээ тусгаарлагдан эмчлүүлэх тухай зөвшөөрлийг бичгээр өгнө.

4.3. Эрүүл мэндийн байгууллага, эмнэлгийн мэргэжилтний өгсөн заавар, зөвлөгөөг чанд мөрдөнө.

4.4. Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвийн эмчтэй өдөрт 2 удаа утсаар эсхүл тандалтын системийн “Эрүүл мэндийн хяналт” хэсэгт байршуулсан хуудсаар өөрийгөө хянаж, үнэн, зөв мэдээллийг өгнө.

4.5. Өөрийн эрүүл мэндэд хяналт тавьж, өөрийгөө хянах хуудсанд бичсэн эмнэлзүйн шинж тэмдэг нэмж илрэх, сэтгэл зүйн тавгүй байдал үүсэх болон өөр зовиур илэрсэн тохиолдолд хяналтын эмчид яаралтай мэдэгдэж, зөвлөгөө, эмнэлгийн тусламж, үйлчилгээ авна.

4.6. Өвчтөн /үйлчлүүлэгч/-д коронавируст халдвар (КОВИД-19)-ын шинж тэмдгээс бусад төрөлжсөн мэргэшлийн тусламж, үйлчилгээ шаардлагатай тохиолдолд харьяа анхан шатны эрүүл мэндийн байгууллагын хяналтын эмч болон 119 дугаарын утсанд хандана.

4.7. Гадаад улсын иргэн бол “Интермед” эмнэлгийн 80105577, “SOS medical” эмнэлгийн 91913122 дугаарын утсанд хандаж зөвлөгөө авна.

4.8. Эмчийн өгсөн зааврын дагуу эм уух ба уусан эмтэй холбоотой урвал гарсан тохиолдолд эмчид яаралтай мэдээлнэ.

4.9. Хувийн ариун цэвэр, халдвараас сэргийлэх дэглэмийг чанд сахиж, бусдад халдвар тараахаас сэргийлнэ.

4.10. Тусгаарлалтын хугацаанд гадагшаа гарах, гэр бүлийн гишүүдтэй ойр байхыг хориглоно.

## **Тав. Аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газрын эрх, үүрэг**

5.1. ХӨСҮТ, ЭМХТ-тэй хамтран эмнэлгийн мэргэжилтнүүдийг коронавируст халдвар (КОВИД-19)-ын эмнэлзүйн шинж тэмдгийг таних, эрэмбэлэн ангилах, эмчилгээ, хяналт, халдвартын сэргийлэлт, хяналт, хамгаалах хувцас хэрэгслийн зөв хэрэглээ, эрүүл мэндийн болон сэтгэл зүйн зөвлөгөө, мэдээлэл хүргэх, сэтгэл зүйн бэлэн байдлын сургалтад хамруулж бэлтгэсэн байна.

5.2. Аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар нь батлагдсан тохиолдлыг гэрийн тусгаарлалтад эмчлэх, хянах шийдвэр гаргах, эрүүл мэндийн байгууллага, эмнэлгийн мэргэжилтнийг мэргэжил арга зүйгээр хангах, сэтгэл зүйн зөвлөгөө өгөх, шаардлагатай тохиолдолд өвчтөнд эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх эмнэл зүйн багийг томилсон байна.

5.3. Аймаг, нийслэл, дүүргийн хэмжээнд мэдээлэл шуурхай солилцох цахим сүлжээг байгуулж, нэгдсэн удирдлага, мэргэжил аргазүйгээр хангаж ажиллах ба тандалтын системийг ашиглах, мэдээллээр хангах зохицуулалтыг хийнэ.

5.4. Гэрийн эмчилгээ, хяналтыг хийх эмнэлгийн мэргэжилтний ажил үүргийн хуваарийг гаргаж баталгаажуулна.

5.5. Шаардлагатай тохиолдолд нэмэлтээр дайчлагдан ажиллуулах эмч, эмнэлгийн мэргэжилтэн, резидент эмч, оюутнуудын судалгааг холбогдох байгууллагатай хамтран гаргаж баталгаажуулсан байна.

5.6. Гэрийн тусгаарлалтад эмчлэгдэж байгаа өвчтөнд төрөлжсөн мэргэшлийн эмчийн тусlamж, үйлчилгээ үзүүлэх, шаардлагатай тохиолдолд хэвтүүлэн эмчлэх эмнэлгийн хуваарийг тусlamж, үйлчилгээний чиглэл, төрлөөр гаргаж, баталгаажуулсан байна.

5.7. Аймаг, орон нутагт эмнэлзүйн багийн өвчтөнд хийсэн үzlэг, оношилгоог үндэслэн сум, тосгоны эрүүл мэндийн төвд, эсхүл аймгийн Нэгдсэн эмнэлгийн халдвартын тасаг болон бусад зохион байгуулсан эмнэлэгт шилжүүлэн эмчлэх асуудлыг шийдвэрлэнэ. Нийслэлд коронавируст халдвартай өвчтөнийг батлагдсан хуваарийн дагуу эмнэлэгт хэвтүүлэн эмчилнэ.

5.8. Эмчилгээ, хяналтад байгаа өвчтөнтэй хамт амьдарч байгаа гэр бүлийн гишүүдэд тандалт хийж, коронавируст халварын эмнэлзүйн шинж тэмдэг илэрсэн тохиолдолд ПГУ-ын шинжилгээ хүлээхгүйгээр эрэмбэлэн ангилж, тусгаарлан, хариу арга хэмжээг шуурхай авна.

5.9. Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвийн эмч нарын тандалтын системийн ашиглалт, холбогдох судалгаа, мэдээнд өдөр бүр хяналт тавьж ажиллана.

5.10. Мэдээлэл солилцох урсгалын дагуу гэрийн тусгаарлалтад эмчилж, хянасан тохиолдлын бүртгэл, судалгаа, эмчилгээний үр дүнгийн талаарх мэдээ, тайланг гаргаж холбогдох байгууллагуудад тухай бүр хүргүүлнэ.

5.11. Орон нутгийн онцгой комисстай хамтран өвчтөнд нийгмийн хамгааллын болон бусад үйлчилгээ үзүүлэх арга хэмжээг тухай бүр авна.

### **Зургаа. Халдварт өвчин судлалын үндэсний төвийн эрх, үүрэг**

6.1. Коронавируст халвар (КОВИД-19)-ын батлагдсан тохиолдлын гэрийн тусгаарлалтад эмчлэх, хянах, тандах, эрүүл мэндийн тусlamж, үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааг мэргэжил арга зүйгээр хангаж, аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар, эрүүл мэндийн байгууллагатай хамтран ажиллана.

6.2. Шаардлагатай тохиолдолд гэрийн тусгаарлалтад эмчилгээ, хяналтад байгаа өвчтөний хамт амьдарч байгаа гэр бүлийн гишүүдээс авсан ПГУ-ын шинжилгээний сорьцыг баталгаажуулан шуурхай мэдээлнэ.

6.3. Тандалтын системийн холбогдох мэдээ, мэдээллийг нэгтгэн дүгнэх, нөхцөл байдлын үнэлгээ, дүгнэлт хийж, мэдээллээр хангаж ажиллана.

Эрүүл мэндийн сайдын 2021 оны  
**04** дүгээр сарын-~~01~~...ны өдрийн **10/039**  
 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

“Коронавируст халдварт (КОВИД-19)-ын батлагдсан тохиолдлын  
 гэрийн тусгаарлалтад эмчлэгдэх өвчтөн /үйлчлүүлэгч/-д хийх үнэлгээний хуудас”  
 /Маягт №1/

Аймаг, нийслэл, сум, дүүрэг, хорооны нэр: .....

Эрүүл мэндийн байгууллагын нэр: .....

Үнэлгээ хийсэн ажилтны нэр, албан тушаал: .....

Үнэлгээ хийсэн огноо: 20 ... оны ..... сарын .... –ны өдөр

№	Асуумж	Тийм	Үгүй
		✓ тэмдгээр тэмдэглэнэ үү	
<b>А. Эрсдэлт хүчин зүйлсийн үнэлгээ</b>			
1.	Зүрх судасны архаг өвчинтэй эсэх		
2.	Чихрийн шижин өвчинтэй эсэх		
3.	Элэгний архаг өвчинтэй эсэх		
4.	Уушгины багтраа болон уушгины бусад архаг эмгэгтэй эсэх		
5.	Беөрний архаг эмгэгтэй эсэх		
6.	Мэдрэлийн архаг эмгэгтэй эсэх		
7.	Цусны архаг өвчтэй эсэх		
8.	Сэтгэцийн эмгэгтэй эсэх		
9.	Хорт хавдараар өвчилсөн эсэх		
10.	Эрхтэн шилжүүлэн суулгах мэс засал хийгдсэн эсэх		
11.	ХДХВ/бусад дархлаа дарангуйлагдах эмгэгтэй эсэх		
12.	Бодисын солилцооны өвчин эсхүл бусад ямар нэг өвчний улмаас үүссэн таргалалттай эсэх		
13.	Бусад хавсарсан хүнд өвчтэй эсэх		
14.	Жирэмсэн эсэх		
Дээрх өвчний онош батлагдаж, эмчийн байнгын хяналтад байдаг бол 1 асуултад “тийм” гэж хариулсан тохиолдолд эмнэлэгт хэвтүүлэн эмчилнэ.			
<b>Б. Гэр ахуйн орчин, нөхцлийн үнэлгээ</b>			
1	Гэрт нь утасны болон интернэтийн сүлжээ бий юу?		
2	Өвчтөн өөрөө болон асран халамжлагч нь утасны болон интернэтийн сүлжээг ашиглан эмнэлгийн мэргэжилтнүүдтэй тогтмол мэдээлэл солилцож чадах юу?		
3	Өвчтөнийг гэрт нь тусгаарлан эмчлэх эрүүл ахуйн орчин, нөхцөл бүрдсэн ўу?	Орон сууцанд амьдардаг юу? Тусад нь 1 өрөөнд тусгаарлах боломжтой юу? Цөөн ам бүлтэй юу? /ам бүлийн тоо 5-аас доош/	
4		60-аас дээш насны хүн Архаг хууч өвчтэй	

	Гэр бүлд нь эдгээр эрсдэлт бүлгийн хүн хамт амьдардаг уу?	5 хүртэлх насын хүүхэд Байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй Сэтгэцийн эмгэгтэй Дархлаа дарангуйлах эмгэгтэй Жирэмсэн эмэгтэй	
5	Өвчтөнг асран халамжлах, туслах хүн байгаа юу?	Гэр бүлийн гишүүдээс хэн нэгэн хүн түүнийг асран халамжилж хамт байх боломжтой юу? Өвчтөн гэртээ ганцаараа амьдардаг бол түүнд тусалж, дэмжлэг үзүүлэх хүн байгаа юу?	
6	Гэртээ халдвараас сэргийлэх дэглэмийг мөрдөх нөхцөл, боломж байгаа юу?	Гарын ариун цэврийг сахих нөхцөл /угаалтуур, усан хангамж/ байгаа юу? Ариун цэврийн хэрэгслийн нөөц бүрдүүлэх боломжтой юу? /саван, алчуур гэх мэт/ Гэртээ цэвэрлэгээ, халдвартгүйтгэл тогтмол хийж чадах уу? /ахуйн хэрэглээний цэвэрлэгээ, халдвартгүйтгэлийн бодис, угаалгын нунтаг, алчуур, бээлий гэх мэт/ Гэр бүлийн гишүүдээс тусдаа ариун цэврийн өрөө ашиглах боломжтой юу? эсхүл ариун цэврийн өрөөний цэвэрлэгээ, халдвартгүйтгэлийг тогтмол хийж чадах уу?	
7	Бусад хүний хөл хөдөлгөөнийг хязгаарлах боломжтой юу?		
8	Өвчтөн болон асран халамжлагч, гэр бүлийн гишүүд хувийн хамгаалах хэрэгсэл ашиглах эдийн засгийн боломж /худалдан авах/ байгаа юу?	Амны хаалтыг 4 цаг тутамд, шаардлагатай үед тухай бүр сольж чадах уу? Нойтон болон цаасан арчуур, гар халдвартгүйжүүлэгч гэх мэт зүйлийг худалдан авч хэрэглэж чадах уу? Асран халамжлагч өвчтөнтэй харьцсан тохиолдол бүрт цэвэрлэгээ, халдвартгүйтгэл хийх ус, шингэн нэвтэрдэгтүй хормогч, бээлий, хогийн уут, сав хэрэглэх боломж байгаа юу?	
9	Гэрээр тусгаарлан эмчлэхийг зөвшөөрч байгаа юу?	Өвчтөн өөрөө Асран халамжлагч, Гэр бүлийн гишүүд	

Дээрх асуумжийн 4 дэх асуултад “үгүй”, бусад асуултад “тийм” гэж хариулсан тохиолдолд гэрийн тусгаарлалтад эмчилгээ, хяналтыг хийнэ. Гэрийн тусгаарлалтад эмчлэгдэх тухай зөвшөөрлийг “Маягт №3”-ын дагуу бичгээр авна.

**Коронавируст халдварт (КОВИД-19)-ын батлагдсан тохиолдлын  
гэрийн тусгаарлалтад эмчлэгдэж байгаа өвчтөний өөрийгөө хянах хуудас  
/Маягт №2/**

<b>Хүн ам зүйн мэдээлэл:</b>								
Овог:				Нэр:				
Нас (жил, сараар): <u>  </u> жил <u>  </u> сар				Хүйс: Эрэгтэй <u>  </u> , Эмэгтэй <u>  </u>				
Регистрийн дугаар		<u>  </u>			Төрсөн огноо: <u>  </u> он <u>  </u> сар <u>  </u> өдөр			
Утасны дугаарууд		<u>  </u> , <u>  </u>						
Иргэншил								
Гэрийн хаяг								
Хэрэв гадаадын иргэн бол байрлаж буй газар, хаяг		Байрлаж буй газрын нэр:..... Дэлгэрэнгүй хаяг:..... .....						
Нийгмийн байдал		Албан хаагч <u>  </u> , Ажилчин <u>  </u> , Ажилгүй <u>  </u> , Оюутан <u>  </u> , Сурагч <u>  </u> , Хувиараа <u>  </u> , Тэтгэвэрт <u>  </u> , Малчин <u>  </u> , Цэцэрлэг <u>  </u> , Гэрт <u>  </u> , Бусад: .....						
Ажлын газрын хаяг (ажил, сургууль, цэцэрлэг)								
Мэргэжил, албан тушаал								
Ам бүлийн тоо		<u>  </u>						
Өдрийн дугаар, ажиглах давтамж	Халуурах ≥37.0 хэм	Амт мэдрэх гүй болох	Үнэр мэдрэхгүй боловх	Хоолой өвдөх	Хуурай ханиалгах	Ядарч сульдах	Амьсгаадах, Амьсгалын тоо /1 мин-д 20- оос дээш/	Бусад (бичих)
1	Өглөө	Тийм <input type="checkbox"/> Үгүй <input type="checkbox"/>	Тийм <input type="checkbox"/> Үгүй <u>  </u>	Тийм <input type="checkbox"/> Үгүй <u>  </u>	Тийм <input type="checkbox"/> Үгүй <input type="checkbox"/>	Тийм <input type="checkbox"/> Үгүй <input type="checkbox"/>	Тийм <input type="checkbox"/> Үгүй <input type="checkbox"/>	Тийм <u>  </u> Үгүй <u>  </u>
	Орой	Тийм <input type="checkbox"/> Үгүй <input type="checkbox"/>	Тийм <input type="checkbox"/> Үгүй <u>  </u>	Тийм <input type="checkbox"/> Үгүй <u>  </u>	Тийм <input type="checkbox"/> Үгүй <input type="checkbox"/>	Тийм <input type="checkbox"/> Үгүй <input type="checkbox"/>	Тийм <input type="checkbox"/> Үгүй <input type="checkbox"/>	Тийм <u>  </u> Үгүй <u>  </u>
2	Өглөө	Тийм <input type="checkbox"/> Үгүй <input type="checkbox"/>	Тийм <input type="checkbox"/> Үгүй <u>  </u>	Тийм <input type="checkbox"/> Үгүй <u>  </u>	Тийм <input type="checkbox"/> Үгүй <input type="checkbox"/>	Тийм <input type="checkbox"/> Үгүй <input type="checkbox"/>	Тийм <input type="checkbox"/> Үгүй <input type="checkbox"/>	Тийм <u>  </u> Үгүй <u>  </u>
	Орой	Тийм <input type="checkbox"/> Үгүй <input type="checkbox"/>	Тийм <input type="checkbox"/> Үгүй <u>  </u>	Тийм <input type="checkbox"/> Үгүй <u>  </u>	Тийм <input type="checkbox"/> Үгүй <input type="checkbox"/>	Тийм <input type="checkbox"/> Үгүй <input type="checkbox"/>	Тийм <input type="checkbox"/> Үгүй <input type="checkbox"/>	Тийм <u>  </u> Үгүй <u>  </u>
3	Өглөө	Тийм <input type="checkbox"/> Үгүй <input type="checkbox"/>	Тийм <input type="checkbox"/> Үгүй <u>  </u>	Тийм <input type="checkbox"/> Үгүй <u>  </u>	Тийм <input type="checkbox"/> Үгүй <input type="checkbox"/>	Тийм <input type="checkbox"/> Үгүй <input type="checkbox"/>	Тийм <input type="checkbox"/> Үгүй <input type="checkbox"/>	Тийм <u>  </u> Үгүй <u>  </u>



		Үгүй [ ]	Үгүй I [ ]	Үгүй I [ ]	Үгүй [ ]	Үгүй [ ]	Үгүй [ ]	Үгүй I [ ]	
	Орой	Тийм [ ] Үгүй [ ]	Тийм [ ] Үгүй I [ ]	Тийм [ ] Үгүй I [ ]	Тийм [ ] Үгүй [ ]	Тийм [ ] Үгүй [ ]	Тийм [ ] Үгүй [ ]	Тийм I [ ] Үгүй I [ ]	
10	Өглөө	Тийм [ ] Үгүй [ ]	Тийм [ ] Үгүй I [ ]	Тийм [ ] Үгүй I [ ]	Тийм [ ] Үгүй [ ]	Тийм [ ] Үгүй [ ]	Тийм [ ] Үгүй [ ]	Тийм I [ ] Үгүй I [ ]	
	Орой	Тийм [ ] Үгүй [ ]	Тийм [ ] Үгүй I [ ]	Тийм [ ] Үгүй I [ ]	Тийм [ ] Үгүй [ ]	Тийм [ ] Үгүй [ ]	Тийм [ ] Үгүй [ ]	Тийм I [ ] Үгүй I [ ]	
Дараах шинж тэмдгийн аль нэг нэмж илэрвэл өрх, сум, тосгоны эмчид утсаар яаралтай мэдэгдэнэ. Үүнд:					<ul style="list-style-type: none"> <li>• Өндөр халуурах /халуун бууруулах эм ууснаас хойш 2 цагийн дотор халуун буурахгүй байгаа/</li> <li>• Амьсгал давчдах</li> <li>• Бүтэн өгүүлбэрээр ярьж чадахгүй амьсгаадах</li> <li>• Уруул, хэл, амны салст хөхрөх</li> <li>• Ханиалгарт нэмэгдэх</li> <li>• Цээжээр өвдөх</li> <li>• Бөөлжих</li> <li>• Суулгах</li> <li>• Тууралт гарах</li> <li>• Нүд үрэвсэх</li> <li>• Булчингаар өвдөх</li> </ul>				
					<ul style="list-style-type: none"> <li>• Үе мөч өвдөх</li> <li>• Хамраас цус гарах</li> <li>• Татах</li> <li>• Ухаан балартах.</li> </ul> <p>Хэрэв пульсоксиметр байгаа бол зааврын дагуу тайван үед хэрэглэж, 1 минут дахь зүрхний цохилтын тоо, SpO2 (сатураци) буюу захын цусны хүчилтөрөгчийн ханамжийг тодорхойлно. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>• Зүрхний цохилтын тоо 1 минутад &gt;100 байх</li> <li>• SpO2 (сатураци) &lt;94% байх.</li> </ul> <p><b>Жич:</b> Өвчтөнд амьсгал тоолох аргыг зааж өгсөн байх ба эсхүл эмнэлгийн мэргэжилтэн цахим үзлэг хийж, амьсгалын тоо, пульсоксиметрийн үзүүлэлтээр биеийн байдалд үнэлгээ өгнө.</p>				

Эрүүл мэндийн сайдын 2021 оны  
07 дүгээр сарын-21-ны өдрийн 07/039  
дугаар тушаалын гуравдугаар хавсралт

**Коронавируст халдварт (КОВИД-19)-ын батлагдсан тохиолдлын  
гэрийн тусгаарлалтад эмчлэгдэх өвчтөний зөвшөөрлийн хуудас (Маягт №3)**

**А. Эмч коронавируст халдварт (КОВИД-19)-ын эмнэлзүйн шинж тэмдэг, эдгэрэлт, хүндрэлийн талаар үйлчлүүлэгчид ойлгомжтойгоор тайлбарлана:**

Коронавируст халдварт (КОВИД-19)-ын эмнэлзүйн хөнгөн хэлбэрийн шинж тэмдэг илэрсэн ч гарч болох эрсдэл, хүндрэлүүд (нэг бүрчлэн дурдана)-ийг тайлбарлана:

Гэрийн эмчилгээ, хяналтын үед баримтлах халдвараас сэргийлэх дэглэм (нэг бүрчлэн дурдана)

Гэрийн эмчилгээ, хяналтын үед үйлчлүүлэгч болон асран хамгаалагчтай харилцаа холбоо тогтоох, зөвлөгөө, мэдээлэл авах заавар (нэг бүрчлэн танилцуулж, бичгээр өгнө)

**Б. Коронавируст халдварт (КОВИД-19)-ын эмнэлзүйн шинж тэмдэг, эдгэрэлт, хүндрэл, эмчилгээ, хяналт, халдвараас сэргийлэх дэглэмийн талаар **БИ ТОДОРХОЙ МЭДЭЭЛЭЛ АВСАН БА ЭМЧИЛГЭЭ, ХЯНАЛТЫН ДЭГЛЭМИЙГ ЧАНД МӨРДӨХ БОЛНО.****

Үйлчлүүлэгчийн овог нэр, утасны дугаар: ..... /гарын үсэг/ .....

Миний аав, ээж, нөхөр, эхнэр, хүүхэд, дүү (хэн болохыг доогуур зурж тэмдэглэх) -гээ асран халамжлахыг зөвшөөрч байна.

Асран халамжлагчийн овог нэр, утасны дугаар: ..... /гарын үсэг/.....

Гэр бүлийн нэг гишүүн /хэн болохыг бичих/-ий овог нэр, утасны дугаар: .....

Зөвшөөрөл авсан эмнэлгийн ажилтны нэр: ..... /гарын үсэг/.....

Эмчтэй холбоо барих утасны дугаар, имэйл хаяг:

Үйлчлүүлэгч болон асран халамжлагчтай холбоо барих цахим хаяг:.....

огноо: ..... он ..... сар ..... өдөр

Энэхүү зөвшөөрлийн хуудсыг 2 хувь үйлдэнэ.

---oo---